

2020 оны 04 сарын 16 өдөр

№ 20/30

Улаанбаатар

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-д*Хүсэлт гаргах тухай*

Тус компанийн 2020 оны 4-р сарын 02-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэм, үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах мөн томоохон хувьцаа эзэмшигчийн компанид хувьцаагаа эргүүлэн худалдах саналыг хүлээн авахаар шийдвэрлэсэн.

Бид хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, тэгш байдлыг хангах үүднээс энэхүү шаардах эрхийг хэрэгжүүлж байгаа болно.

Иймд 2020 оны 4-р сарын 02-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй болон хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 53, 54-р зүйлүүдэд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд өөрийн цахим хуудасаар албан ёсоор мэдэгдэж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.АМАРТҮВШИН

2020 оны 04 сарын 16 өдөр

№ 20/33

Улаанбаатар

**“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК /Регистрийн дугаар №5106583/ нь 2020 оны 4-р сарын 02-ны өдөр хуралдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа компанийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулж, компанийн дүрэмд зохих өөрчлөлтийг оруулахаар шийдвэрлэсэн.

Тус компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орж байгаа болон томоохон хувьцаа эзэмшигчийн компанид хувьцаагаа эргүүлэн худалдах саналыг хүлээн авч байгаатай холбогдуулан 2020 оны 4-р сарын 02-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй болон хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг энэхүү зараар уламжилж байна.

Хаяг: Монгол улс, улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж-ба, Сити плаза 202 тоот.

Утас:70139949, 98011009 /Гүйцэтгэх захирал О.Амартүвшин/

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХУВЬЦААТ КОМПАНИ

2020 оны 04 сарын 16 өдөр

№ 20/32

Улаанбаатар

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ийн 2020 оны 4-р сарын 02-ны
өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын...-р тогтоолын хавсралт.

2020/003

**Компанийн хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар
Компани өөрийн гаргасан хувьцаагаа эргүүлэн
худалдан авах журам**

Тус компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орж байгаа болон томоохон хувьцаа эзэмшигчийн компанид хувьцаагаа эргүүлэн худалдах саналыг хүлээн авч байгаатай холбогдуулан 2020 оны 4-р сарын 02-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцоогүй болон хурлаас гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 53,54-р зүйлүүдэд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн.

Компаний эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг Компанийн тухай хуулийн 53.5, 2020 оны 4-р сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэнийг үндэслэн компанийн гаргасан нэгж энгийн хувьцааг хувьцаа эзэмшигчдээс худалдан авах үнийг 300\гурван зуун төгрөг\ төгрөгөөр тогтоож байна.

1. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 54-р зүйлд зааснаар шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь шаардлагыг компанид бичгээр гаргана. Мөн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд данс нээлгэсэн байх ба дараахь баримт бичгийг бүрдүүлнэ. **Үүнд:**

- Шаардах эрхээ хэрэгжүүлэхийг хүссэн өргөдөл /“ҮЦТХТ”-ийн маягтаар/
- Эзэмшиж буй хувьцааны тоог нотлох бичиг баримт /Дансны албан ёсны хуулга, харилцдаг брокер диллерийн компаниас бичгээр гаргасан албан ёсны тодорхойлолт гэх мэт /
- Иргэний үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Төвлөрсөн хадгаламжийн данснаас мөнгө хүссэн өргөдөл /“ҮЦТХТ” ХХК-ийн маягтаар /

-Хэрэв хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй бусдад энэхүү эрхээ шилжүүлсэн бол нотариатаар баталгаажуулсан албан ёсны итгэмжлэл

2. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3-д зааснаар хувьцаа эзэмшигч нь компанид хувьцааг эргүүлэн худалдах тухай өөрийн шаардлагыг уг эрхийг үүсгэсэн шийдвэр гарснаас, эсхүл ийм эрх үүссэн тухай компаниас олон нийтийн мэдээлэлийн хэрэгслэлээр мэдээлснээс хойш ажлын 30 хоногийн дотор компанид хүргүүлнэ.

Энэхүү хугацаанд хувьцаа эзэмшигч нь нь шаардлага гаргаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хугацаа хожимдуулж гаргасан шаардлагыг Компани шаардлага гаргасан гэж үзэхгүй буюу ийнхүү шаардлага гаргасан тохиолдолд Компани нь хувьцаагаа эргүүлэн худалдан авах үүрэг хүлээхгүй.

3. Компаний хувьцаа эзэмшигчийг 2020 оны 4-р сарын 02 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, хувьцаагаа буцаан худалдах хүсэлт зэрэг бусад холбогдох материалтай танилцах боломжоор Компани хангах үүрэгтэй.

5. Компани нь хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны хадгаламжийн байгууллага дахь “ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК -ийн дансанд байршуулна. Компани нь санхүүгийн байдлаас шалтгаалан шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авснаас хойш ... сарын дотор шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

6. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 33-р зүйлийн 33.7 -д зааснаар Компани өөрийн хувьцааг худалдан авах буюу эргүүлж авбал эдгээр хувьцааг зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцно. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Компани эдгээр хувьцааг дахин гаргаж болно.

Шаардах эрх хэрэгжүүлэх комисс:

1“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП”ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Амартүвшин Утас:

2“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП”ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга У.Анар Утас:99958282